



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 24,000,000.00 (хорин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, 14,333,333.31 (арван дөрвөн сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа, Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001761





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн  
213 дугаар тогтоолын хавсралт

Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах автомашин

| Д/д | Автомашинны марк,<br>улсын дугаар, арал  | Үйлдвэрлэсэн,<br>ашиглалтад<br>орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ<br>(төгрөг)               | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                                                                                                         | Үлдэх өртөг<br>(төгрөг)                                                                                                             | Саргаан босголт<br>(төгрөг) | Худалдах доод<br>үнэ (төгрөг)                       | Дэнчингийн<br>хэмжээ<br>(төгрөг) |
|-----|------------------------------------------|-----------------------------------------|-----------------|----------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------------------------------|----------------------------------|
| 1   | Старекс, 53-44<br>БУЛ,<br>арал №40587568 | 2004/<br>2012                           | 445000          | 24,000,000.00                          | 14,333,333.31                                                                                                                             | 9,666,666.69                                                                                                                        | 0                           | 9,700,000.00                                        | 2,425,000.00                     |
|     | Нийт дүн                                 |                                         |                 | 24,000,000.00<br>(хорин дөрвөн<br>сая) | 14,333,333.31<br>(арван дөрвөн<br>сая гурван зуун<br>гучин гурван<br>мянга гурван<br>зуун гучин<br>гурван төгрөг<br>гучин нэгэн<br>мөнгө) | 9,666,666.69<br>(есөн сая<br>зургаан зуун<br>жаран зургаан<br>мянга зургаан<br>зуун жаран<br>зургаан төгрөг<br>жаран есөн<br>мөнгө) | 0                           | 9,700,000.00<br>(есөн сая<br>долоон зуун<br>мянган) |                                  |